



БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 ОН

АГУУЛГА

I.	Ерөнхий мэдээлэл	01-06
	○ Удиртгал	
	○ Зорилго	
	○ Паркийн танилцуулга, мэдээлэл	
	○ Өнөөгийн байдал	
II.	Бизнесийн стратеги	07-08
	○ Бүтээгдэхүүн ба үйлчилгээ	
III.	Зах зээлийн шинжилгээ	09
IV.	Хөгжүүлэлтийн төлөвлөгөө	10-11
V.	Санхүүгийн төлөвлөгөө	 12
VI.	Хавсралт	13-15
	○ Эхлэлтийн зардал	
	○ Мөнгөн гүйлгээний тайлан	

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1. УДИРТГАЛ

Инновац, технологийг бий болгох, нутагшуулах замаар эдийн засгийг төгөлдөржүүлэх, олон тулгуурт хөгжлийн гарцыг бий болгох нь манай улсын нэн тэргүүнд тавигдаж буй бодлого юм. Үүний тулд эдийн засгийн чөлөөт бүс хэлбэрээр шинжлэх ухаан, технологийн паркийг байгуулах замаар салбарын төвлөрсөн аж үйлдвэрийн кластерийн орон зайг хөгжүүлэх шаардлага урган гарч байгаа юм. Өндөр технологийн шийдэл нь үйлдвэрлэлд нэвтэрч улмаар нэмүү өртөг шингэсэн таваар болох нь улс орны өрсөлдөөний давуу тал, эдийн засгийн чадавхыг илэрхийлэх нэгэн чухал үзүүлэлт болж байна. Дэлхийн туршлагаас харахад тухайн технологийн салбарт тэргүүлэх байр суурь эзлэх гэсэн хүсэл эрмэлзэл нь өөрийн нутаг орондоо тухайн салбарын мэдлэгийг бий болгохоос эхэлж байна. Тэргүүлэх салбарын хүрээнд эрдэмтэн судлаачид, хувийн хэвшил зэрэг оролцогч талуудын хамтын ажиллагаанд төр засаг зохистой дэмжлэг үзүүлснээр өндөр нэмүү өртөг бүхий экспортын чиглэмжтэй таваарын үйлдвэрлэлийн төрөлжсөн орон зайг хөгжүүлж байгаа хэлбэр нь технологийн парк болж байгаа юм.

Монгол улсад өнөөгийн байдлаар төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжиж буй жилүүдийн нөхцөл байдлаас харахад “шинжлэх ухаан – үйлдвэрлэл” гэсэн гинжин холбоосыг бий болгохыг эрмэлзэж байгаа боловч шинжлэх ухаан, технологийн шинэчлэлд тулгуурласан инновацын механизмын үйл явц үндсэндээ байхгүй байна. Тухайлбал, манай улсын эдийн засгийн хөгжилд гол нөлөө үзүүлэх хүнд, хөнгөн үйлдвэрлэлийн эрэлт маш их удаашралтай байна. Энэ салбарт тэргүүний технологийн нутагшилт, мэдлэгийн эдийн засгийн эргэлтэд орох үйл явц удаашралттай байгаа нь салбарын өрсөлдөх чадварт муугаар нөлөөлж байна.

Энэхүү нөхцөл байдлыг өөрчлөх, бүс нутгийн хэмжээнд өрсөлдөх чадварыг нь нэмэгдүүлэх зорилгоор юуны өмнө нийслэлийн төвлөрийг сааруулж, иргэдийн тархаан суурьшуулах үүрэгтэй шинэ суурьшлуудыг бий болгох, нийгэм эдийн засаг, байгаль орчны зохистой харьцааг хангах, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх замаар, төлөвлөгдсөн газрыг паркийн бүс болгон хөгжүүлэхэд чиглэсэн төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг зохион байгуулах, нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж, Хүнд болон Хөнгөн үйлдвэрлэлийн салбарт байгаль орчинд ээлтэй, шинэ, дэвшилтэт болон өндөр технологид суурилсан бүтээгдэхүүн дамжуулах, нэвтрүүлэх, нутагшуулахад тээвэр логистикийн хамгийн гол чиглэл Улаанбаатар-Замын-Үүд Багахангай дүүргээр дамжин өнгөрдөг тул технологийн салбарын дэмжлэгтэйгээр дэмжиж өндийлгөх нь салбарын нэн тэргүүнд тавигдах асуудал болж байна.

“Багахангайн үйлдвэрлэлийн технологийн парк”-т /цаашид парк гэнэ/ нь экспортод чиглэсэн стратегийн бүтээгдэхүүний төрлийг нэмэгдүүлэх, Сэргээгдэх эрчим хүч угсралтын үйлдвэр болон хөнгөн үйлдвэрийн салбарт шинжлэх ухааны ололт,

дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх, бизнесийн таатай орчинг бүрдүүлж, кластер үйлдвэрлэлийн цогцыг хөгжүүлэхэд тулгуурлан ажиллаж байна.

1.2 Бизнес төлөвлөгөөний зорилго

Бизнес төлөвлөгөөнд паркийн үйл ажиллагааны одоогийн байдлыг тодорхойлон дүгнэж, цаашид үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хийх шаардлагатай өөрчлөлт шинэчлэлт, зохион байгуулалт, түүнийг хэрэгжүүлэх нөөц бололцоог тодорхойлон боловсруулав.

Төлөвлөгөө нь 2025 онд гүйцэтгэх ажлын үндсэн чиг хандлагаар боловсруулагдсан учир паркийн ажилтан бүрийн ажлын чиглэл, үйлдвэрлэл үйлчилгээг удирдан зохион байгуулах гол баримт бичиг болно.

1.3 Паркийн танилцуулга

Анх нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны А/146 дугаар тогтоолоор 14 хүний орон тоотой байгуулагдан, 6 дахь жилдээ үйл ажиллагаа явуулж байна. 2025.01.01-ний өдрөөс нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 36 дугаар тогтоолоор ХК болон хуулийн хэлбэр өөрчлөгдсөн.

Тус парк нь дүүргийн 1-р хорооны нутаг дэвсгэрт 139.9 га газар эзэмшдэг бөгөөд хөнгөн, хүнд үйлдвэрлэлийн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж, гадаад, дотоодын аж ахуйн нэгж байгууллагаас хөрөнгө оруулалт татах, хамтран ажиллах санал санаачлагыг гарган ажилладаг.

Бодлогын баримт бичигт:

Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилт, Багахангай дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрүүдэд “Багахангайн үйлдвэрлэл, технологийн парк байгуулна” гэж заасан байдаг.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт:

3.3 Улаанбаатар хотыг үйлдвэрлэл, инновацын төв болгон төрөлжүүлэн хөгжүүлж, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжинэ.

3.3.1 Багахангай үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтыг дуусгана.

3.3.2 Багахангай дүүрэгт хүнд үйлдвэрлэлийн үйлдвэрлэл, технологийн паркийг дагалдах бусад үйлдвэрийн хамт байгуулах хувийн хэвшлийг дэмжин зорилтыг тавин ажиллаж байна.

Паркийн үйл ажиллагааны талаарх товч мэдээлэл:

Одоогоор паркт тээвэр логистик нэгдсэн төвийн "Тен фрейт лайн" ХХК, вагоны хос дугуй угсрах нэгдсэн төв байгуулах "Эл эс рэйлвэйс" ХХК, Кокс эрчим хүчний

цогцолбор үйлдвэрийн "Сарьдаг Хангай Оргил" ХХК-иуд гэрээ байгуулан, нэгжээр орсон.

Нэгжээр орсон 3 аж ахуйн нэгж байгууллагаас идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй "Сарьдаг хангайн оргил" ХХК нь БНХАУ-ын 100%-ийн хөрөнгө оруулалттай 2.7 тэрбум юань мөнгөн дүн бүхий төсөвт өртөгтэй, Кокс эрчим хүчний үйлдвэр барих бүтээн байгуулалтын барилга угсралт, 1-р ээлжийн бүтээн байгуулалтын ажил 90% гүйцэтгэлтэй байна.

Үүнд:

- Оффисын барилгын ажил 93%-тай
- Хоолны газрын барилгын ажил 80%-тай.
- Ажилчдын байрны барилгын ажил 80%-тай
- Агуулах, дулаан гражын барилгын ажил 60%-тай
- Галд тэсвэртэй материал үйлдвэрийн барилгын ажил 50%-тай
- Нүүрсний агуулах 50%-тай
- Нүүрс угаах үйлдвэр, баяжуулах 40%-тай
- Бүтээгдэхүүн боловсруулах цех нүүрс шахах хэлбэржүүлэх 78%-тай
- 1-р зуухны байгууламж 89%-тай
- Лаборатори барилга 75%-тай
- Төслийн талбайд 88 гадаад, 15 монгол улсын иргэд ажиллаж байна.



2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр "Эл Эс Рэйлвэй ХХК", "Тен Фрейт Лайн" ХХК-ууд паркийн хөнгөн үйлдвэрлэлийн 61 га газрын 8 га газарт вагоны хос дугуй засварлах, тээвэр логиستيкийн нэгдсэн төв байгуулах төслийг хэрэгжүүлэхээр шав тавьсан.



Мөн дэд бүтцийн зураг төслийн ажлыг төр, хувийн хэвшлэлийн түншлэлээр шийдвэрлэгдсэн.

Үүнд:

Нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр:

2024.01.16-ны өдөр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, НЗД-ын нэгдүгээр орлогч П.Сайнзориг нар паркийн бүтээн байгуулалтын явцтай танилцсан. Уг ажлын хүрээнд паркийн эрчим хүчний бүтээн байгуултын ажлын 4.7 км урттай 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугамын 1.8 тэрбум төгрөгийг 2024 оны төсвийн тодотголоор шийдвэрлэгдсэн.




2019-2025 онд Улс, Нийслэлийн төсөв, хувийн хэвшил, бусад эх үүсвэрээс хийсэн хөрөнгө оруулалт:

№	Хөрөнгө оруулалтын ажил	Хугацаа /он/	Хөрөнгө оруулалт /сая.төг/	Эх үүсвэр /улсын төсөв, нийслэл, дүүргийн төсөв г.м/
1	Техник, эдийн засгийн үндэслэл	2019	145,0	Нийслэл
2	Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, Барилгажилтын төсөл	2022	192,6	Нийслэл
3	Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ	2022	ХЕТ-ний ажлын даалгаварт хавсрагдаж хийгдсэн.	Нийслэл
4	“Хөгжлийн төлөвлөгөө”	2022	27,0	Дүүрэг
5	Хашаажуулалтын зураг төсөл	2023	5,0	Хувийн хэвшил

6	“Цахилгаан Эрчим хүчний” “8МВт-ын суурилагдсан чадал бүхий 35/10кВ-ын дэд станцын зураг төсөл	2022	130,0	Эрчим хүчний яам
7	“Техник, технологийн түвшний үнэлгээ”	2022	15,0	БХБЯ
8	Цахилгаан хангамжийн “Техникийн нөхцөл” болон, “Зургийн ажлын даалгавар” хийгдсэн.	2022	-	Эрчим хүчний яам
9	Авто замын зураг төсөл	2023	60,0	Нийслэл
10	Ус хангамж, Ариутгах татуургын гадна, дотно зураг төсөл	2023	55,0	Нийслэл
11	Дулаан хангамжийн шугам сүлжээний зураг төсөл	2023	53,0	Нийслэл
12	Паркийн хонгилын системийн зураг төсөл	2023	61,0	Нийслэл
13	Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ	2024	10,0	Нийслэл
14	Үер, усны байгууламжийн зураг төсөл	2024	34,5	Нийслэл
15	Мэдээлэл, холбоо хангамжийн зураг төсөл	2024	15,8	Нийслэл
16	4,7 км урттай 2 хэлхээт 35/10КВн ЦДАШ	2024	1,8 тэрбум	Нийслэл
Нийт дүн		2019- 2024	Зураг төсөл 812,9	Нийслэл, Дүүрэг, БХБЯ, Эрчим хүчний яам

Хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд:

Зам, тээврийн хөгжлийн яамны Ж.Болдхүү, “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн Хөдөлгөөний аюулгүй байдал хариуцсан замын орлогч Ш.Нямсүрэн даргаар ахлуулсан ажлыг хэсэг паркт ирж ажилласан. Уг ажлын хүрээнд салбар Төмөр Зам салаалах хүсэлтийг газар дээр нь судалж үзээд өртөөний салгалттай засварын 10 дугаар мухар зам, 29 дүгээр суман шилжүүлгийн ард 12.5 метрт баруун гарын суман шилжүүлэг тавьж, паркийн эзэмшлийн талбай хүртэлх салбар төмөр замыг зураг төслийн дагуу салаалан барих боломжтой гэж дүгнэлт гаргасан.. Өртөөний өргөтгөл, паркийн эзэмшил үйлдвэрийн бүс рүү төмөр замын салаа татах зураг төсөв бүрэн хийгдэж дууссан. “Улаанбаатар төмөр зам” ХНН-тэй зөвшилцөх өртөөний өргөтгөлийн ажил гүйцэтгэх компани сонгох асуудлаар хэлэлцэгдэж байна.



1.4 ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Төлөвлөлтийн хугацаа

Эхний ээлж:

- 2020-2023 он Зураг төслийн ажлууд бүрэн хийгдэж, дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх үе шат

Хоёрдугаар ээлж:

- 2023-2025 он 500-1510 шинэ ажиллах хүч бүхий ажлын байр хөнгөн үйлдвэрлэлийн бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх үе шат

Гуравдугаар ээлж:

- 2025-2030 он ажилчдын тоог 1510-2125 хүртэл нэмэгдүүлэх үйлдвэрийн кластеруудын бүтээн байгуулалтын үе шат

Давуу тал

- Үйлдвэрийн бүсийн байршилд нийт 139.9 га тусгай хэрэгцээний эзэмшил газартай.
- Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуультай.
- Боловсруулах аж үйлдвэрт хөрөнгө оруулах сонирхолтой аж ахуйн нэгжүүдтэй
- Шаардлагатай зураг төслийн ажлууд 100% хийгдсэн.
- 4.7 км ЦДАШ -ын ажил хийгдсэн. Төвийн эрчим хүчээр хангагдах боломжтой
- Мал аж ахуйн түүхий эдийг боловсруулан хөнгөн, хүнсний үйлдвэрлэл хөгжүүлэх (фермер, хүлэмж г.м) боломжтой
- Паркт нэгжээр гэрээ байгуулж орсон аж ахуйн нэгжүүд ойрын хугацаанд дэд бүтцэд холбогдох боломжтой.
- Улаанбаатар хотын дүүрэг статустай, Төвийн бүсэд байрладаг
- Паркийн үйл ажиллагааг нийтэд сурталчлах өөрийн вэб хуудастай.

Боломж

- Монгол орны эрдэс баялгийн нөөцийг ашиглаж хүнд үйлдвэрлэл байгуулан хөгжүүлэх боломжтой. Түүхий эдийн нөөцийг төмөр зам болон авто замаар тээвэрлэх боломжтой. Нийслэл хот болон урд хойд хөрштэй дэд бүтцээр холбогдсон.
- Инженерийн дэд бүтцийг өргөтгөх, нэмэгдүүлэх боломжтой.
- Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг түшиглэн шинээр компаниуд бойжуулах боломжтой.
- АҮЭБЯ, Хот байгуулалт, Барилга, орон сууцжуулалтын яам болон Нийслэлийн ЗДТГ-аас зохих дүрэм, журмуудад паркийн чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэлийг нарийн тусгаж өгсөн.

II. БИЗНЕСИЙН СТРАТЕГИ

1. Паркийн удирдлага, зохион байгуулалтанд орчин үеийн менежментийн арга барилыг тууштай нэвтрүүлнэ.
2. Паркийн үйлдвэрлэл, үйл ажиллагаа, технологийн хөгжлийн зорилго Байгаль орчинд халгүй, хаягдалгүй, дэвшилтэд технологи бүхий, экспортын чиг баримжаатай, импортын бүтээгдэхүүнийг орлох үйлдвэрлэлийн төсөл, хөтөлбөрүүдийг дэмжин хэрэгжүүлнэ.
3. Санхүүгийн хөгжлийн зорилго Паркийн төсөвт зардлыг хэмнэх, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх санхүүгийн удирдлагыг нэвтрүүлэх замаар паркийн бие даасан байдлыг хангах урт хугацааны бодлогыг баримтлана.
4. Нийгэм эдийн засгийн хөгжлийн зорилго Бүс, орон нутгийн үйлдвэржилтийг дэмжиж, нийгэм, эдийн засгийг тогтвортой хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд оролцоно.
5. Шинжлэх ухаан, инноваци Эрдэм шинжилгээ, шинэ бүтээлийн судалгаа, туршилтыг явуулж инновацийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.
6. Байгууллагын үйл ажиллагаанд Монгол улсад дагаж мөрдөж буй стандартуудыг нэвтрүүлэх.

○ Бүтээгдэхүүн ба үйлчилгээ

Бүтээгдэхүүн үйлчилгээний нэр	Кокс эрчим хүч үйлдвэрлэх төсөл	Логистикийн нэгдсэн төв байгуулах төсөл	Вагоны хос дугуй засварлах төсөл
Бүтээгдэхүүн үйлчилгээний эрэлт хэрэгцээ, шаардлага	Коксын дотоодын хэрэгцээг хангах(250.000тн) Гангийн үйлдвэрлэлд томоохон ахиц дэвшлийг авчрах	Монгол Улсад бүртгэлтэй нийт вагоны 63%-ийг дангаар эзэлж байгаа бол тавцант вагон 18% бусад вагон 0-3% эзэлж байна. Ачааны хагас болон тавцант вагоны тоо хэмжээг нийт вагоны тоо хэмжээтэй харьцуулахад 80 гаруй хувийг эзэлж байгаа нь манай улсын уул уурхайн эрдэс баялагийн экспортын тээвэрлэлттэй холбоотой бөгөөд цаашид ч эдгээр төрлийн вагоны тоо хэмжээ нэмэгдэх хандлагатай байна.	Ачаа тээвэр, агуулах, хадгалалт, хүргэлтийн нэгдсэн цогц үйлчилгээг нэг дороос үзүүлж, эцсийн хэрэглэгчдэд очих бараа материалын үнийг бууруулах
Бүтээгдэхүүн үйлчилгээний онцлог	Металургын өндөр чанарын цэвэр кокс,	Дотоодын хэрэгцээг бүрэн хангахуйц өндөр хүчин чадал	Ачааны терминаль, ангилал ба нийтлэг шаардлага MNS 5832:2007

			стандартыг бүрэн хангасан жилд 700.000 тн ачаа боловсруулах хүчин чадалтай “А” зэрэглэлийн бүрэн механикжсан логистикийн нэгдсэн төв байгуулах
Бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх боломж шийдэл	Дотоодын зах зээлд өндөр чанарын кокс нэвтрүүлэх	Ирээдүйд бий болох вагоны өсөлтийн таамаглалыг нэмж тооцвол Монгол Улсад нийт 29,677 нэгж вагон тээвэрлэлт хийх буюу түүнд 118,708 нэгж хос дугуй ашиглагдах юм. Энэхүү хэрэгцээг хангах боломжтой.	Жижиг дунд бизнес эрхлэгчдийг хямд өртөгтэй түрээсийн агуулах, контейнер, талбайгаар ханган зардлыг бууруулж, үр ашгийг нэмэгдүүлэх
Хэрэглэгчийн ямар хэрэгцээг хангах, нийгэмд үзүүлэх үр нөлөө	Хүнд үйлдвэрүүдийг түүхий эдээр хангах. Таван толгой түлш” ХХК-д кокс нийлүүлснээр Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах.	Монгол улсад тээвэрлэлтэд явж байгаа 10038 нэгж вагоны 40152 ширхэг хос дугуй засвар үйлчилгээг хийх.	Улаанбаатар хотыг дотогш биш гадагш чиглэлд тэлж хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах. Хот хоорондын ачаа түгээлтийг Улаанбаатар хотын гадна хийх, хүргэлт түгээлтийн үйлчилгээг сайжруулах
Бүтээгдэхүүн үйлчилгээний өрсөлдөх чадвар	Одоогоор зах зээлд өрсөлдөгч байхгүй.	1. УБТЗ ХНН ЗХ-Вагон депо 2. УБ Зорчигчийн вагон депо 3. Дархан, УБ, СШ, Баянтүмэн Зүтгүүрийн депо 4.Болдтөмөр ерөө гол ХХК 5. Монголын Төмөр Зам	Улаанбаатар хотод Пик пак агуулах. Бүсийн хэмжээнд ижил төстэй өрсөлдөгч байхгүй.

III. ЗАХ ЗЭЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ

SWOT шинжилгээ

Компанийн дотоод хүчин зүйлс	
Давуу тал	Сул тал
•Төлөвлөлт, төлөвлөгөөг үндэслэлтэй хийдэг •Боловсруулах аж үйлдвэрийг хөгжүүлж, экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэн, зах зээлд гаргах үйлдвэрлэлийн болон түүхий эдийн нөөцийг ойроос тээвэрлэх, татах боломжтой •Мал аж ахуйн түүхий эдийг боловсруулан хөнгөн, хүнсний үйлдвэрлэл хөгжүүлэх боломжтой • Гадаад дотоод зах зээлд гарцтай, нийслэл хот болон урд хойд хөрштэй дэд бүтцээр холбогдсон •Паркийн үйл ажиллагааг нийтэд сурталчлах, хөрөнгө оруулагчдад зөв мэдээллийг хүргэх, солилцох, хамтрах чиглэлүүдийг судлах боломжтой •Инженерийн дэд бүтцийг өргөтгөх, нэмэгдүүлэх боломжтой.	Зөвшөөрөл олгогдсон газар нутгийн талбай харьцангуй бага • Ур чадвартай инженер техникийн ажилтан, ажилчид, зах зээлийн мэдлэгтэй мэргэжилтнүүдийг бэлтгэх шаардлагатай. • Эдийн засгийн салбарын бүтэц нь тогтоогүй, томоохон үйлдвэр, бренд бизнес хөгжөөгүй, • Оршин суугчдын болон хөдөлмөрийн насны хүний тоо бага, ажиллах хүчний хомсдолд орох магадлалтай • Ойрын усны эх үүсвэр
Компанийн гадаад хүчин зүйлс	
Боломж	Эрсдэл
Паркийн нэгж “Сарьдаг хангайн оргил” ХХК бүтээгдэхүүнээ • Шинэ зах зээлд гарах, томоохон хэрэглэгчтэй шууд худалдааны гэрээ байгуулах боломжтой. • Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг түшиглэн шинээр компаниуд бойжуулах боломжтой. •Хүнд болон хөнгөн үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах боломжтой. • АҮЭБЯ, Хот байгуулалт, Барилга, орон сууцжуулалтын яам болон Нийслэлийн ЗДТГ-аас зохих дүрэм, журмуудад Багахангайн ҮТП-ийн чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэлийг нарийн тусгаж өгсөн.	Зах зээлийн үнээс хамаарал өндөр • Мэргэжлийн ажиллах хүчний хангалтаас өндөр хамааралтай • Хөрөнгө оруулалтын эх үүсвэр олдохгүйн улмаас цаг алдах нөхцөл үүсэх аюултай.

IV. ПАРК ХӨГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Бодлогын үндэслэл	Үндсэн үйл ажиллагаа, төсөл арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин		Зорилтот түвшин (хувь)	Санхүүжилт (сая.төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа
					Он	Түвшин (хувь)			
1	ЗГҮАХ ШСБ НХТЖҮЧ НЗДҮАХ	Багахангайн үйлдвэрлэл технологийн парк байгуулах	Паркийн 4.7 км урттай 2 хэлхээт ЦДАШ-ын 35/10КВ-ын бүтээн байгуулалтын ажлыг хүлээн авах	Хувь	2024	90	100	-	II-IV улирал
2			Хүнд болон хөнгөн үйлдвэрийн тусгай зөвшөөрөл авах ажлын гүйцэтгэл	Хувь	-	-	100	-	II-IV улирал
3			Паркийн эзэмшил газарт салаа төмөр зам татах ажлын бичиг баримтын бүрдэлийг хангах ажлын гүйцэтгэл	Хувь	2024	Зургийн ажил хийгдсэн.	100	-	II-IV улирал
4			Мэдээлэл холбооны техникийн нөхцөлийн хугацааг сунгуулах ажлын гүйцэтгэл	Хувь	2023	-	100	-	II-IV улирал
5			Цахилгаан хангамжийн 2000 МВа техникийн нөхцөлийг гаргуулах ажлын гүйцэтгэл	Хувь	2023	-	100	-	II-IV улирал
6			Дэд бүтцийн үлдсэн 4 зураг төслийн ажлыг НХОГ-с хүлээн авах ажлын гүйцэтгэл	Хувь	2024	Зургийн ажил хийгдсэн.	100	-	II-IV улирал
7			Хөгжлийн төлөвлөгөөний санхүүжилтийг шийдвэрлүүлэх ажлын гүйцэтгэл	Хувь	-	-	100	90.0 сая төгрөг	II-IV улирал
8			Цахилгаан хангамж 35/10КВ-ын 2х8МВА дэд станцийн бүтээн байгуулалтын ажлын санхүүжилтийг холбогдох шатны байгууллагад санал хүргүүлэн ажиллах, шийдвэрлүүлэх ажлын гүйцэтгэл	Хувь	2024	1.8 тэрбумын шугамын ажил хийгдсэн.	100	4.3 тэрбум төгрөг	II-IV улирал
9			Паркийн нэгж болох "Эл эс рэйлвэй" ХХК, "Тен фрейт лайн" ХХК-ийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх	Хувь	2024	Гэрээ байгуулс ан.	10	-	I-IV улирал
10			Аж ахуйн нэгж байгууллагын тоог нэмэгдүүлэх	Тоо	2024	1	2	-	I-IV улирал

11			Гэрээ байгуулсан ААН байгууллагуудтай хамтран ажлыг байрыг нэмэгдүүлэх	Тоо	2024	200	300	-	I-IV улирал
12			Паркийн нэгжүүдийг дүүрэгт шилжүүлэн ирүүлэх	Тоо	-	-	2	-	I-IV улирал

1. ПАРКИЙН САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус парк нь 2020-2024 онд Нийслэлийн төсвөөс санхүүжиж, төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээ, санхүүгийн тайлан гарган, нийслэлийн төрийн сангаар хянуулж, төсвий байгууллагын зарчмаар ажиллаж ирсэн.

Засгийн газраас баталсан төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн хэмжээнд дүйцүүлэн байгууллагын даргын тушаалаар үндсэн цалинг тогтоож, орон нутгийн нэмэгдэл, ур чадварын нэмэгдэл, төрд ажилласан жилийн нэмэгдэл, унаа хоолны нэмэгдэл зэргийг сар бүр, үр дүнгийн урамшууллыг улирал бүр төрийн үйлчилгээний албан хаагчийн жишгээр олгодог.

Нийслэл дэх Төрийн аудитын газраас байгууллагын 2020, 2021, 2022 онуудад санхүүгийн тайланд аудит хийж, ӨӨРЧЛӨЛТГҮЙ ДҮГНЭЛТ ирүүлсэн учраас 2023 оны тайланд ИТГЭЛ үзүүлсэн.

Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг тайланг хугацаанд нь тогтмол гаргаж, Сангийн яамны <https://ehuulga.mof.gov.mn/> системийн мэдээлэлтэй тулгаж, баталгаажуулдаг.

Албан хаагчдын нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлан, ХХОАТ тайланг хуулийн хугацаанд үнэн зөв гаргаж, баталгаажуулан өр авлаггүй ажиллаж байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дах хэсэг “төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” 41 дүгээр зүйлийн 41.2.2 дах хэсэгт “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэж заасныг тус тус баримталж, төсвийн жилд өр авлага үүсгэхгүй ажиллаж, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны 43, 2022 оны 203, 204, 2023 оны 240, 2024 оны 82, 128 дүгээр тогтоолын дагуу батлагдсан төсвийг зориулалтын дагуу хэмнэлттэй, үр өгөөжтэй зарцуулан, хэмнэлттэй ажиллаж байна.

4. Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлан

ХӨРӨНГӨ	2024 оны жилийн эцсийн байдлаар	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧИЙН ДҮН	2024 оны жилийн эцсийн байдлаар
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	0	Богино хугацаат өр төлбөр	0
Авлага	0	Урьдчилж орсон орлого	0
Материал хангамжийн зүйл	6,005,760	Урт хугацаат өр төлбөр	0
Эргэлтийн хөрөнгийн дүн	6,005,760	Өр төлбөрийн дүн	0

Биет хөрөнгө	16,349,280	Засгийн газрын сан	660,928,156
Биет бус хөрөнгө	969,882,083	Дахин үнэлгээний нэмэгдэл	0
Эргэлтийн бус хөрөнгө	51,714,660.33	Тайлант үеийн үр дүн	331,308,966
ХӨРӨНГИЙН ДҮН	992,237,122	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧИЙН ДҮН	992,237,122

4.1. Хөрөнгийн задаргаа

• Бичиг хэрэг		295,550	
• Аж ахуйн материал		5,710,210	
• Тоног төхөөрөмж	30ш	10,894,403	/элэгдэл байгуулсан дүн/
• Тавилга хэрэгсэл	39ш	5,454,877	/элэгдэл байгуулсан дүн/
• Програм хангамж	2ш	1,602,667	/элэгдэл байгуулсан дүн/
• Газар	123,3га	565,509,840	
• Зургийн ажил	5ш	402,769,576	
Нийт дүн		992,237,122	

5. 2024 оны төсвийн гүйцэтгэл - 2025 оны зорилтот түвшний төсөл


Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ний өдрийн “Нийслэлийн 2025 оны төсөв батлах тухай” 24/33 дугаар тогтоолоор тус паркад дүрмийн сангийн хөрөнгөө өсгөх зорилгоор 600 сая төгрөг батлагдсан. Батлагдсан төсвийг Нийслэлийн төрийн сангаас 150 саяаар 4 хувааж улирал бүр олгохоор хуваарийг батлуулсан байна.

Хүснэгт1

№	ТҮСВЭЙН	2024 он		2025 он	
		Өөлөвлөгөө	Аүйцэтгэл	Байгууллагын санал	Хянасан
1	Нийслэлийн төсвийн санхүүжилт	408,575,000	408,575,000	600,000,000	
1.1	Борлуулалтын орлого	-		-	
	Нийт орлого	408,575,000	408,575,000	600,000,000	
	Нийт зардал	408,575,000	408,575,000	600,000,000	
2.1	ТУЗ-ийн урамшуулал	-	-	86,802,000	
2.2	ТУЗ-ийн НДШ /12.5хувь/	-	-	10,850,250	
2.3	ТУЗ-ийн хуралдааны зардал	-	-	4,000,000	
2.4	Цаёёл, нэмэгдэл, унаа хоол	341,620,400	295,248,212	414,274,000	

2.5	Àæèè ìëãîã-îî ìëéãìëéí àààòãàëä ò°è°ð øèìòãýë	42,702,500	36,226,600	49,581,700	
2.6	Ажлын байрны түрээс, ашиглалт	9,486,500	9,485,364	18,395,196	
2.7	Интернет, шуудан холбооны зардал	1,860,000	1,174,800	1,474,800	
2.8	Оффис хангамж	3,586,600	3,586,600	5,654,600	
2.9	Тээврийн хэрэгслийн зардал	4,780,000	4,780,000	6,000,000	
2.10	Урсгал засвар	-	-	820,000	
2.11	Äîîïä àëáàí òîëëëïèð	500,000	482,000	-	
2.12	Бусад зардал	1,750,000	1,661,040	11,809,604	
2.13	Хөдөлмөр хамгаалал	994,000	994,000	-	
2.14	Мэдээлэл технологийн үйчилгээ	795,000	791,000	1,320,000	
2.15	Íýä ôáàããäëéí òýðãýìæ òðàìòóóëàë	500,000	500,000	1,500,000	
4	Төвлөрүүлэн шилжүүлэг		53,645,384		

БАТЛАГДСАН ТӨСӨВТ ЗАРДЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ



ДҮГНЭЛТ

1. Батлагдсан бүтэц, орон тоонд хүргэж ажиллах /цалин хөлстэй холбоотой төсвийг нэмэгдүүлэх,
2. Паркийн тусгай зөвшөөрөл авах, газрын хэмжээг нэмэгдүүлэх, техникийн нөхцөл авах зэрэг ажлуудыг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг нэмэгдүүлэх,
3. Үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн зураг төсөл, бүтээн байгуулалтыг эрчимжүүлэхэд төр, хувийн хэвшлийн түншлэл, гадны зээл тусламжаар хөрөнгө оруулалтыг татахад танилцуулга бэлтгэх, хөрөнгө оруулагчидтай уулзалтууд зохион байгуулах, төр хувийн хэвшлийн оролцоог хангахад дүүргийн иргэд, олон нийтэд сурталчлах,
4. Паркийн дэд бүтцийн барилга байгууламжийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх ажлыг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхэд бага үнийн дүнтэй зургийн ажил, байгууллагын үйл ажиллагааны танилцуулга... гэх мэт/-уудыг урсгал үйл ажиллагааны санхүүжилтээр гүйцэтгэх,
5. Байгууллагын компьютер, принтер нь элэгдлээрээ өртөгөө нөхсөн тул техник хэрэгслийн шинэчлэл хийх,
6. Орлого нэмэгдүүлэх боломжийг эрх зүйн хүрээнд судлах,

[illegible]

[illegible]